

ОРЧИН ҮЕИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВШИЛД ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ.

С.Наранбаатар.

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч, магистрант, цагдаагийн дэд хурандаа.

Б.Одбаатар.

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессоровын багийн профессор, доктор (Ph.D),

Товч агуулга. Энэхүү нийтлэлээр Монгол Улсын цагдаагийн байгууллагыг дэлхийн хөгжлийн чиг хандлага, улс орны нийгэм-эдийн засгийн онцлог болон бусад нөхцөл байдлын өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан орчин үеийн цагдаагийн байгууллага болж төлөвшихөд төвлөрлийг сааруулах зарчмын хэрэгжүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх зарим асуудлын талаар авч үзэхийг зорилго.

Түлхүүр үгс. цагдаагийн байгууллагын хөгжил, төвлөрөлийг сааруулах зарчим, цагдаагийн байгууллагын удирдлага.

Оршил. Манай улс социалист төвлөрсөн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжиж эрх зүйн бүх салбар, тэр дундаа хууль сахиулах салбарт шинэтгэлийн үйл ажиллагааг хийсэн төдийгүй түүний дотор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоо бүхий хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актуудад нилээд өөрчлөлт орсон. Шинэчлэлийн үе шатуудад Цагдаагийн байгууллага хэмээх ойлголтыг 2013, 2017 оны

Өдгөө цагдаагийн эрх зүйн шинжлэх ухаанд цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг судлан хамгийн оновчтой хэлбэрийг бий болгох нь практикт ихээхэн ач холбогдолтой төдийгүй энэ нь дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн орчин үеийн цагдаагийн байгууллага болж төлөвшихөд чухал алхам болох юм. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын стратеги, удирдлага, зохион байгуулалт, төрөл

мэргэжлийн албадын үйл ажиллагаа, алба хаагч, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, цагдаа, олон нийтийн хамтын ажиллагааг уялдуулан сайжруулах, өөрчлөх шаардлага бий болсоор байна.

Орчин үеийн цагдаагийн шинэ үзэл санаа бол байгууллагын шинэ стратеги юм¹. Энэ стратегийн гол асуудал нь :

- төвлөрлийг сааруулах.
- нэгж дээр ажиллаж буй алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх.
- цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй байх тухай асуудал юм.

Төвлөрлийг сааруулах гэдэг нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас тодорхой эрх мэдлийг харьяа нэгж, хэсэгт шилжүүлэх, хоёрдугаарт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдыг нэгж, салбар, хэсэгт ажиллуулах тухай асуудал юм.

¹ Хоролсүрэн. М, Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. Уб., 2004. 16 дахь тал.

Төвлөрлийг сааруулах тухай ойлголтыг байгууллагын жишээнд авч үзвэл байгууллагын төвийн нэгжид ажиллаж буй алба хаагчдыг тодорхой нутаг дэвсгэрт хуваарилах замаар төвлөрлийг задалж захын дүүрэг, хороо, сумдад ажиллуулах тухай ойлголт бөгөөд энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд :

- Төрийн ажил, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг оновчтой тодорхойлох алхам бий болох.

- Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцлийг богино хугацаанд олж тогтоох, аливаа гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах боломжийг олгох.

- Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны цар хүрээнд эерэг өөрчлөлт гарах.

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, татан оролцуулах үйл ажиллагаанд ахиц гарах.

- Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд цагдаагийн анхан шатны нэгж олноор бий болж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа идэвхжих зэрэг ач холбогдолтой.

Орчин үеийн цагдаагийн онолын хувьд төвлөрлийг сааруулах гол чухал элементийн нэг нь зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт байдаг. Энэ онолоор байгууллага нь гурваас дээшгүй зохион байгуулалтын шатлалтай байна гэж үздэг¹. Үүнийг цагдаагийн байгууллагын бүтцийн хувьд авч үзвэл:

- цагдаагийн анхан шатны нэгж.

- дэмжлэг үзүүлэх мэргэжлийн нэгж.

- байгууллагын менежмент буюу удирдлагын баг гэж ойлгож болно.

Энэхүү загварыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцэд хөрвүүлж үзвэл:

- Анхан шатны нэгж болох сум, орон нутаг дахь цагдаагийн хэсгийн бүтцийг интеграцичлах замаар өргөтгөх.

- Алба хаагчдын ажил, үүргийг нэгтгэх арга хэлбэрээр төрөлжүүлэх, орон тоог нэмэгдүүлэх.

- Анхан шатны нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтаас илүүтэйгээр төвийн буюу аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн удирдлагаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогыг тодорхойлж, нэгжийг удирдах асуудал юм.

Байгууллагын төвлөрлийг сааруулах чиглэлээр ажиллах ерөнхий цар хүрээг бий болгох нь зүйтэй юм. Аливаа зорилго өөрчлөгдөн шинэчлэгдсэн ч тодорхой нөхцөл байдалд уян хатан ажиллах чадвартай бүтцийг бий болгохын зэрэгцээ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх тодорхой ажил үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд илүү сайн хуваарилах явдал гэж тодорхойлж болох юм.

Судлаачийн зүгээс цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх ажил, үйлчилгээг жигд хүртээмжтэй болгох, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан анхан шатны нэгж дэх зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох чиглэлээр өндөр хөгжилтэй улс орны цагдаагийн анхан шатны нэгжийн бүтцийг судласан.

Япон улс. Тус улс нь засаг захиргааны 47 мужаас бүрдэх бөгөөд

¹ Хоролсүрэн. М, Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. – Уб., 2004. 126 дахь тал.

тус улсын цагдаагийн ерөнхий газар нь мужийн цагдаагийн газраар дамжуулан хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тус улсад жижиг суурин, тосгонд цагдаагийн үйл ажиллагаа нь /Meji revolution/ буюу иргэний цагдаагийн системээр ажилладаг байна. Тус улсад 1986 оны үед Мейжийн хувьсгалын дараагаар энэхүү системийг хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах болсон ба цагдаагийн энэхүү систем нь гол төлөв хөдөө, тосгон, жижиг суурин газарт илүү тохиромжтой зохион байгуулалтын бүтэц юм¹.

Системийн гол зорилго нь хэв журам сахиулах, хуулийг мөрдүүлэх үйл ажиллагаа байдаг бөгөөд цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх зохион байгуулалт нь /кобан/ байр юм. Өөрөөр хэлбэл кобан хэлбэрийн зохион байгуулалт нь тус улсын цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж болдог. Японд 14100 орчим цагдаагийн кобан байдаг ба нийт цагдаагийн алба хаагчдын 20 орчим хувь нь кобан системээр ажилладаг. Кобан нь цагдаагийн туслах байцаагч, цагдаагийн түрүүч, цагдаа, олон нийтийн цагдаа гэх бүтэц, зохион байгуулалтаар ажилладаг байна.

Кобанд 3-5 тооны алба хаагч ажиллах бөгөөд тэдгээрийн өдөр тутмын ажил үүрэг нь гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авах, сэжиг бүхий этгээдийг шалгах, эргүүл хийх, хэрэг учралын газарт хамгаалалт хийх, гэмт этгээдийг баривчлах, эрэн сурвалжлалт явуулах гэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Кобан нь орон нутгийн иргэдтэй цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийттэй хамгийн ойр харилцах харилцааны хамгийн тохиромжтой арга хэлбэр гэж үздэг.

¹ Japan 1986 the revolution was meant for political and social structure.

² Энхжаргал. Х, Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын зохион

Сингапур улс. Тус улсын цагдаагийн байгууллага нь олон нийт иргэдийн туслалцаатай нутаг дэвсгэр, орон нутгийн нийгмийн бүтэц дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хууль сахиулах үйл ажиллагааны гол хүч нь сайн дурын цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа юм. Сайн дурын цагдаагийн алба хаагчдын дийлэнх хувь жижиг хот, сууринд ажиллах ба гол төлөв явган эргүүлийн үүргийг гүйцэтгэдэг. Сингапур улсад орон нутгийн цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжийн бүтэц нь хөршийн цагдаагийн төв юм². Энэ нь манай улсын цагдаагийн байгууллагын хэсэг, тасгийн бүтэцтэй ижил төстэй боловч үйл ажиллагаа нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах үзэл баримтлалд үндэслэгдэн зохион байгуулагдсан байдаг.

Хөршийн цагдаагийн төв нь 12-16 алба хаагч багийн зохион байгуулалтад орж 8 цагаар, ээлжээр үүрэг гүйцэтгэн ажиллах ба Япон улстай адил чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эндээс дүгнэн үзвэл дээрхи улс орнуудад хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхдээ орчин үеийн цагдаагийн шинэ үзэл санаа /reactive/-г хэрэгжүүлэх, байгууллага дахь төвлөрлийг сааруулах зарчмыг баримтлаж байгаа нь ажиглагдаж байна.

Орон нутгийн цагдаагийн байгууллагын төвлөрлийг сааруулахад бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн хэмжээ, түүний удирдлага, зохион байгуулалт, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлс чухал үр нөлөөтэй юм.

байгуулалтын бүтцийн өнөөгийн байдал. магистрын судалгааны ажил. – УБ. 2016. 30 дахь тал.

Цагдаагийн байгууллага, тэр тусмаа орон нутаг дахь цагдаагийн анхан шатны нэгж болох сумын цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд орчин үеийн шаардлага хангасан тогтолцоо, бүтцийг бий болгох нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Цагдаагийн анхан шатны нэгж болох сумдын цагдаагийн хэсгийн одоогийн бүтэц, зохион байгуулалт нь хуучин социалист нийгмийн үеийн зохион байгуулалт бөгөөд орчин үеийн шаардлагад зарим талаараа нийцэхгүй байгаа нь практикт ажиглагдаж байна. Тухайлбал өмнөх нийгмийн тогтолцооны үеийн орон нутгийн болон сумдын хүн амын суурьшилт хөдөлгөөн, тархалт, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн аж төрөх арга хэлбэр, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын өсөлт, бууралт, төрөл, ангилал зэрэг хүчин зүйлс нь өөрчлөгдөж байхад бид өмнөх нийгмийн үед ажиллаж байсан зохион байгуулалтын бүтэц, арга хэлбэрээр шинэ нийгмийн тогтолцооны үедтэмцэх нь учир дутагдалтай юм.

Цагдаагийн албаны тухай хуулийг 2013, 2017 онд шинэчлэн найруулсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 71 дүгээр тушаалаар Нийслэл, дүүрэг болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдийн бүтэц, ажиллах бүрэлдэхүүн, орон тоог урьд ажиллаж байсан төсөв, орон тоонд нийцүүлэн баталсан¹. Мөн газрын даргын 2015 оны Б/99 дүгээр тушаалаар “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох” /код/-105 журмыг батлан

бүтэц, орон тоог тогтоохтой харилцааг зохицуулж өгчээ. Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсээс, хэлтэс нь тасаг, хэсгээс бүрдэнэ” гэж заасан².

Хэдийгээр төв, алба, нэгжийн бүтцийн зохион байгуулалт, орон тоог хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан баталсан боловч сумдад үйл ажиллагаа явуулж буй анхан шатны нэгжийн бүтцийн зохион байгуулалтад төдийлөн анхаарч ач холбогдол өгөөгүй нь учир дутагдалтай буюу орчин үеийн цагдаагийн байгууллага болж төлөвших шинэ үзэл санаанаас ухарсан алхам болсон гэж үзэж байна.

Хууль сахиулах үйл ажиллагааны дэлхийн жишигт хүрэх, орчин үеийн цагдаагийн байгууллага болж төлөвших эхний алхам бол төвлөрлийг сааруулах зарчмыг хэрэгжүүлэх буюу цагдаагийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг хөгжүүлэх, зохион байгуулалтын бүтцийг оновчтой бий болгох явдал юм.

Өнөөдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хүн ам зүйн болон эдийн засгийн байдлаас хамааран аймаг, нийслэлд цагдаагийн газар, хэлтэс, хот, тосгон, дүүрэг, суманд цагдаагийн хэлтэс ихэнхдээ тасаг, хэсгийн нэг загвар маягийн шинжтэй зохион байгуулалтын бүтэцтэй ажиллаж байна. Засаг захиргааны анхан шатны нэгж буюу суманд хэсгийн төлөөлөгч нэг, хэсгийн цагдаа нэг, нийт хоёр орон тоотой албан үүрэг гүйцэтгэдэг. Гэвч энэ зохион

¹ ЦЕГ-ын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/99 дүгээр тушаал. Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох. /код-105/

² Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга).

байгуулалтын бүтэц нь өмнөх нийгмийн үеийн уламжлалт бүтэц төдийгүй өнөөгийн нийгэм-эдийн засгийн хөгжил, өөрчлөлт, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, зам харилцаа, дэд бүтцийн шинэчлэл, хүн амын тархалт хөдөлгөөн зэрэг бусад хүчин зүйлстэй нийцэхгүй байна.

Иймд тухайн сум, орон нутгийн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан бүтэц, орон тооны хувьд өөрчлөлт хийх, цагдаагийн ажил үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх анхан шатны нэгжийг хөгжүүлэх, боловсронгуй болгох зорилгоор аймаг, дүүрэг дэх цагдаагийн байгууллагын төвлөрлийг сааруулах зайлшгүй шаардлагатай болж байна.

Байгууллагын төвлөрлийг сааруулах, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалан цагдаагийн анхан шатны нэгжийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхой судалгаанд үндэслэн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд тулгуурлан явуулан судалгаа явуулж үзлээ. Судалгааны ажиллагаанд тус сумын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн амын шилжилт хөдөлгөөн, гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэрэг нөлөөлөх хүчин зүйлсийг хамруулан авч үзэхийг зорилоо. Тухайлбал:

Газарзүйн байршил. Тус сум нь газар зүйн байршлын хувьд Сэлэнгэ аймгийн баруун урд захад, баруун болон баруун хойд талаараа Орхон аймгийн Жаргалант сум, Булган аймгийн Хангал сум, хойд талаар Булган аймгийн Сэлэнгэ сум, зүүн хойд талаараа Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сум, зүүн болон зүүн урд талаараа Сэлэнгэ аймгийн Хушаат, Орхон, Сант, урд хэсгээрээ

Орхонтуул, Булган аймгийн Орхон сумтай тус тус хил залгадаг. Улаанбаатар хотоос 310 км, Аймгийн төвөөс 220 км, Эрдэнэт хотоос 65 км, Дархан хотоос 110 км зайд байрладаг.

Хот байгуулалт, газрын харилцаа. Баруунбүрэн сумын төв нь Засаг захиргаа, худалдаа үйлчилгээний төв болсон суурин юм. Хот тосгон, бусад суурины газар нийт нутаг дэвсгэрийн 0.40 хувь буюу 1138.98 га талбайг эзэлж байна. Хот тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 67.62га буюу 5.3 хувийг, нийтийн эдэлбэр газар 979.20 га буюу 87.5 хувийг, гэр хорооллын газар 82.33 га буюу 7.2 хувийг тус тус эзэлж байна.

Газар нутаг. Сумын нийт нутаг дэвсгэр 281454 га бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн газар 182819.63 га, ойн сан бүхий газар 96000 га, усан сан бүхий газар 334 га, улсын тусгай хэрэгцээний газар 2.48 га, хот, тосгон бусад суурин газар 1129.15, зам, шугам сүлжээний газар 1168.74 га талбайг тус тус хамарч байна.

Хүн ам. Нийт 3113 хүн амтай 888 өрх байгаагаас өрхийн тэргүүн нь эмэгтэй 64, эрэгтэй 16 өрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 23, иргэн 105, бүтэн өнчих хүүхэд 6, хагас өнчин хүүхэд 36, Цагаан овооны 3-р багт 1425 хүн ам, 412 өрх, Бургалтайн II багт 922 хүн ам, 267 өрх, Ивэнгийн I багт 766 хүн ам, 209 өрх амьдарч байна¹.

Хүн, амын шилжилт, хөдөлгөөний талаарх сүүлийн гурван жилийн дүн мэдээг хүснэгтээр харуулбал²:

¹ Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 2019, 2020, 2021 оны хүн амын тооллогын статистик.

² Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн сан.

	Нийт хүн ам	2019		2020		2021	
		шилжсэн	нэмэгдсэн	шилжилт	нэмэгдсэн	шилжилт	нэмэгдсэн
1	3113	41	54	9	16	29	59

Тус суманд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа.

Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь
2015	22	4.9	12.5
2019	39	11.6	15.6

Тус суманд бүртгэгдсэн зөрчлийн судалгаа¹.

Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн зөрчилд эзлэх хувь
2015	25	-5.1	4.2
2019	45	8.4	5.7

Нийгэм, эдийн засгийн болон бусад нөлөөлөх хүчин зүйлс өөрчлөгдөхийн хэрээр цагдаагийн анхан шатны нэгжээс хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулалтын бүтцийн хувьд уян хатан хэлбэрээр өөрчлөгдөх шаардлагатай.

Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын шилжилт, хөдөлгөөн, тархалт, нягтаршил, газар зүйн байршил, гарсан хэрэг, зөрчлийн тоог харгалзан үзэх түвшинг тогтоож “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний талаарх” Засгийн газрын 153 дугаар тогтоолын дагуу эдийн засгийн зохистой норматив зардлыг тооцсон зохион байгуулалтын бүтцийг бий болгох нь зүйтэй гэж үзэж байна. Цагдаагийн анхан шатны нэгж бүр нь адилхан зохион байгуулалтын бүтэцтэй байх албагүй бөгөөд тухайн нэгжийн хэрэгжүүлэх ажлын үндсэн цар хүрээ болон гаднын хүчин зүйлсээс хамааралтай байх нь оновчтой юм.

Ийнхүү судалгаанаас үзвэл тус суманд хүн амын нягтаршил, суурьшилт, тархалтын тоо нэмэгдсэн, гэмт хэрэг, зөрчлийн гаралт тогтмол өссөн, зам, харилцааны нөхцөл байдал жил бүр өөрчлөгдөж буй дүр зураг ажиглагдаж байгаа нь эрүү, хэв журмын нөхцөл байдал ижил төсөөтэй анхан шатны нэгжүүдэд зохион байгуулалтын бүтцийн

шинэчлэл шаардлагатай байгаа жишээг харуулж байна.

Дүгнэлт

Орон нутгийн цагдаагийн байгууллагын бүтэц, тогтолцоо, түүнчлэн цагдаагийн анхан шатны нэгж болох сумдын цагдаагийн хэсгийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг тодорхойлж уг бүтцийг орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэх, гадаадын зарим улс орнуудын цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжийн бүтцийг онол практикийн түвшинд харьцуулан үзэх түвшинд дараах дүгнэлтийг гаргав.

Цагдаагийн төв, нийслэл, орон нутгийн цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог уламжлал, шинэчлэлд тулгуурлан сайжруулсан боловч орон нутаг анхан шатны нэгж буюу цагдаагийн хэсгийн зохион байгуулалтын бүтцийг орхигдуулсан гэж дүгнэж байна.

Гадны зарим орны тухайлбал Сингапур, Япон зэрэг улсын цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжийн загварыг сумдад /кобан/ загварын барилга байгууламжийг бүтээн байгуулса нь оновчтой шийдэл байсан боловч анхан шатны нэгжийн зохион байгуулалтын бүтцийг шийдвэрлээгүй нь учир дутагдалтай

¹ Цагдаагийн байгууллагын зөрчлийн мэдээллийн сан.

байна. Иймд Япон улсын цагдаагийн анхан шатны нэгжийн зохион байгуулалтын бүтцийг практик нэвтрүүлэх нь манай улсын нөхцөл байдалд илүү тохиромжтой бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын төвлөрлийг сааруулах чухал алхам болох юм.

Санал

Цагдаагийн анхан шатны нэгж буюу сумын цагдаагийн хэсгийн зохион байгуулалтын бүтцийг:

1. Сумын цагдаагийн хэсгийн бүтцийг Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, Сингапур, Япон зэрэг улс орны цагдаагийн байгууллагын туршлага, орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчил, хүн хөдөлгөөн, суурьшилт зэрэгт үндэслэн хэсгийн төлөөлөгч, мөрдөгч, хэсгийн цагдаа, олон нийтийн цагдаа, зарим тохиолдолд урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн гэсэн 3-4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй анхан шатны нэгжийн зохион байгуулалтад оруулах.

2. Анхан шатны нэгжид чиг үүргийн буюу төрөл мэргэжлийн албан тушаалын орон тоог нэмэгдүүлж цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, алслагдсан орон зайд оршин буй иргэдэд үзүүлэх үйлчилгээг ойртуулах, гэмт хэрэг, зөрчилтэй

тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудалд төр, захиргааны хамтран нягт ажиллах нөхцөлийг бий болгох шаардлагатай байна.

Энэ нь орчин үеийн цагдаагийн үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлагатай нийцэх төдийгүй байгууллага, нэгжийн хөгжлийг сайжруулах стратеги бодлого болж төвлөрлийг сааруулах ач холбогдолтой. Ингэснээр цагдаагийн хэсэгт ажиллаж буй алба хаагчдын үйл ажиллагаа багаар ажиллах, хамтын үйл ажиллагааны хариуцлагад суурилах шинэ хэв загсвар бий болж төлөвшинө гэж үзлээ.

Эх сурвалжийн жагсаалт

1. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл №8.

2. М.Хоролсүрэн. Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. – Уб., 2004.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.

4. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2017.

5. Х.Энхжаргал. Орон нутгийн цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ. магистрын судалгааны ажил. – Уб, 2016.

6. Ortmeier,P.J Joseph J.Davis. Police Adminstration: a Leadership approach. ISBN 978-0-07-338000.